



АШИГТ МАЛТМАЛ,
ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 02 сарын 26 өдөр

Дугаар А/36.

Улаанбаатар хот

Хяналтын хуудасны загвар шинэчлэн
батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Ашигт малтмалын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1 дэх хэсэг, 60.2 дахь хэсэг, Засгийн газрын 2007 оны 81 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын бүтцэд өөрчлөлт орсон тул "Улсын төсвөөс хайгуулын ажилд гарсан зардлын нөхөн төлбөр тооцох, гэрээ хийх хяналтын хуудас"-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан "Хяналтын хуудасны загвар батлах тухай" Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2016 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн а/31 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Улсын төсвийн хөрөнгөөр хийсэн хайгуулын ажлын зардалд ашигт малтмалын ордын нарийвчилсан эрэл, эрэл-үнэлгээний ажлын тухайн талбайд ногдох зардал, хайгуулын бүх шатны ажилд улсын төсвөөс гаргасан зардлын тооцоонд хяналт тавих, нөхөн төлбөрийн гэрээ хийж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, судалгааны хэлтэс /С.Энхболд/, Нүүрс, судалгааны хэлтэс /М.Мэндбаяр/ нарт тус тус үүрэг болгосугай.

4. Тушаалыг хэрэгжүүлж, хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс /Б.Дашпүрэв/ -т даалгасугай.

ДАРГА

Х.ХЭРЛЭН



Ангилал, мэдээлэл, газрын тосны газрын даргын
 2018 оны 08 дугаар сарын 28-ний өдөр
 2018 оны 08 дугаар сарын 28-ний өдөр /тушаалын хавсралт

Бүртгэлийн дугаар:
 Аж ахуйн нэгжийн нэр: "....." ХХК
 Тусгай зөвшөөрлийн дугаар: МУ-.....
 Талбайн хэмжээ: га

УЛСЫН ТӨСВӨӨС ХАЙГУУЛЫН АЖИЛД ГАРСАН ЗАРДЛЫН НӨХӨН ТӨЛБӨР ТООЦОХ,
 ГЭРЭЭ ХИЙХ ХЯНАЛТЫН ХУУДАС

д/д	Хүсэлт шийдвэрлэх үйл ажиллагаа	Гаргасан дүгнэлт, шийдвэр	Гүйцэтгэсэн хугацаа		Хариуцаж гүйцэтгэсэн мэргэжилтэн	
			Хүлээн авсан	Хүлээлгэн өгсөн	Албан тушаал	Нэр гарын үсэг
1	Материал хүлээн авч, бичиг баримтын бүрдлийг шалгах, хяналтын хуудас нээх				УУСХ /НСХ/ -ийн Нөхөн төлбөр хариуцсан мэргэжилтэн	
2	Тухайн тусгай зөвшөөрлийн талбайд хамаарах тайлангийн дугаар, жагсаалтыг гаргаж тэмдэглэх			ГБТА-ын тайлангийн асуудал хариуцсан ажилтан /тохиролцсоноор/		

<p>3</p> <p>Өмнөх геологийн судалгааны материалууд дээр тулгуурлаж төлбөрийн тооцоолол хийх, гэрээний төсөл боловсруулах</p>				<p>УУСХ /НСХ/-ийн Нөхөн төлбөр хариуцсан мэргэжилтэн</p>	
<p>4</p> <p>Өмнөх геологийн судалгааны материалууд дээр тулгуурлаж хийсэн нөхөн төлбөрийн тооцооллыг хянах</p>				<p>УУСХ /НСХ/-ийн ахлах мэргэжилтэн</p>	
<p>5</p> <p>Өмнөх геологийн судалгааны материалууд дээр тулгуурлаж хийсэн нөхөн төлбөрийн тооцоололтой танилцах, гэрээг баталгаажуулах.</p>				<p>УУСХ /НСХ/-ийн дарга</p>	